

## АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН 2014 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН МЭДЭЭЛЭЛ

**Төл бойжилт:** Аймгийн дүнгээр 701.3 мянган толгой буюу төллөх хээлтээгчийн 76.6 хувь төллөж, 692.2 мянган төл 98.7 хувиар бойжиж байна.

**Мал онд оролт:** Мал сүргийн онд оролт 99.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.3 хувиар бага байгаа ба 19324 мал хорогджээ.

**Үнэ:** Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн, малын үнэ сүүлийн сард харьцангуй тогтвортой байсан ба малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорхи ханштай байлаа.

Сар	I	II	III	IV
1 кг ноолуурын үнэ мянган төгрөг	60.0	55.0	50.0	70.0

Гол нэрийн барааны үнэ сумдад зах зээлийн зайнаас хамаарч харилцан адилгүй байгаагийн дээр аймгийн төвд гурил 1кг нь 900-1000, сайн чанарын шар, цагаан будаа 1900-2000, элсэн чихэр 1800, ногоон цай 5000-6500 төгрөгийн дундаж ханштай байна.

**Аж үйлдвэр:** Аж үйлдвэрийн салбарт 4 тэрбум 541.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 83.8 сая төгрөгөөр бага байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 84.4 хувь буюу 3 тэрбум 835.5 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

**Төсвийн орлого:** Орон нутгийн төсөвт 3 тэрбум 392.4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 107.5 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 273.8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 95.4 хувиар тус тус биелүүлж, аймгийн төсвийн нийт орлого 3 тэрбум 666.2 сая төгрөгийн биелэлттэй байна.

**Хүн ам:** Аймгийн хэмжээнд 452 эх амаржиж 454 хүүхэд мэнд төрлөө. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх оны мөн үеэс 95 тохиолдлоор нэмэгдсэн байна.

**Ажилгүйдэл** 2 сарын эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйдчүүд 1214 болсны дотор 55.1 хувь буюу 669 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйдчүүдийн 259 нь дээд, 481 нь тусгай дунд, 287 нь бүрэн дунд, 96 нь суурь, 37 нь мэргэжлийн анхан шатны, 45 нь бага, 9 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна.